

2

МОНГОЛ УЛСАД ЗАХ ЗЭЭЛИЙН ЭДИЙН ЗАСГИЙН ҮНДСЭН ЗАРЧМУУД ХЭРЭГЖИЖ БАЙГАА БАЙДАЛ: СОРИЛТ, БЭРХШЭЭЛ

Б.Батмөнх

Хураангуй: Энэхүү эрдэм шинжилгээний өгүүлэлд Монгол Улсын хөгжлийн өнөөгийн загвар ямар байгаа, зах зээлийн эдийн засгийн үндсэн зарчмууд Монгол Улсад хэрхэн хэрэгжиж байгаа болон ямар бэрхшээл, хүндрэл, сорилтууд тулгарч байгааг хөндөж, ХБНГУ –ын хөгжлийн загвар болох нийгмийн баримжаатай зах зээлийн эдийн засгийн үндсэн зарчмууд, тэдгээрээс Монгол Улсын ирээдүйн хөгжлийн загварт тусгах асуудлыг дэвшүүлсэн.

Abstract: This academic thesis aims at studying current development model of Mongolia, and understanding how major principles of market economy have been implemented in Mongolia. Also it studies obstacles, difficulties and challenges which can be faced to implement market economy principles in full extent in Mongolia. It presents major principles of the Social Market Economy model, the model of the Germany. Also it investigates about the opportunity of implementing major principles of Social Market Economy model in Mongolia.

Түлхүүр үг:

- Нийгмийн баримжаатай зах зээлийн эдийн засаг
- “Цочир эмчилгээний” загвар
- “Градуалист” буюу “үе шатлалт” загвар
- Ордолиберализм
- Субсидиаритэтын зарчим

Өмнөтгөл

Дэлхийн улс орнуудын эдийн засаг, нийгмийн хөгжлийн өнөөгийн загвар, хөгжиж ирсэн түүхэн нөхцөл, уламжлал өөр байсныг бид мэднэ. Эдгээрийн дотор хүнийг хөгжлийн төвдөө тавьсан нийгмийн баримжаатай хөгжлийн загварууд ихээхэн анхаарал татаж байна. Яагаад гэвэл ийм загвараар хөгжсөн олон улс орнууд эдийн засгийн урт хугацааны тогтвортой өсөлтийн зэрэгцээ нийгмийн хөгжлийн асуудлаа үе шаттайгаар шийдвэрлэж, хүн амынх нь

амьжиргаа өндөр түвшинд хүрчээ. Эдгээрийн нэг нь “нийгмийн баримжаатай зах зээлийн эдийн засагтай” ХБНГУ юм. Бид Скандинавын Швед, Норвег зэрэг орнуудын нийгмийн баримжаатай хөгжлийн загварыг жишээ татаж болно. Өнөөдөр үсрэнгүй хурдан хөгжлөөрөө дэлхийн анхаарлын төвд байгаа манай өмнөд хөрш БНХАУ эдийн засаг, нийгмийн хөгжлийн загвараа “зах зээлийн социализм”-ын загвар гэж нэрлэдэг.

Бид ХБНГУ-ын жишээн дээр нийгмийн баримжаатай зах зээлийн эдийн засаг Монгол Улсын ирээдүйн хөгжлийн загвар болж чадах эсэх, ер нь манай орны хөгжлийн өнөөгийн загвар ямар шинж төрхтэй байгаа, нийгмийн ардчилсан шударга ёс, зах зээлийн эдийн засгийн хөгжлийн зарчмууд хэрхэн амьдралд биелэлээ олж байгаа, ямар бэрхшээл, хүндрэл, сорилтууд тулгарч байгаа, шийдвэрлэх ямар асуудлууд байгаа талаар өргөн хүрээтэй судалгааны ажлыг хийж, нухацтай дүгнэлт гаргаж, нэгдсэн ойлголт, үнэлгээ, дүгнэлттэй болох шаардлага байгаа юм.

Монгол Улсын эдийн засаг, нийгмийн хөгжлийн өнөөгийн загвар

Саяханыг болтол Европын Холбоо Монгол Улсыг зах зээлийн эдийн засагтай орон гэж үзэхгүй байсаар ирсэнийг манай эрх баригчид ихэд эмзэглэж байсан. Манай зарим улс төрчид Монгол Улс зах зээлийн эдийн засагт бүрэн шилжсэн гэж үздэг. Ер нь энд маргаантай, судлах асуудлууд цөөнгүй байна.

Монгол Улс Үндсэн хуулийнхаа эхэнд “Монголын ард түмэн бид...эх орондоо хүмүүнлэг, иргэний ардчилсан нийгэм цогцлуулан хөгжүүлэхийг эрхэм зорилго болгоно” гэж тунхагласан. Үндсэн хуулийн нэгдүгээр бүлгийн нэгдүгээр зүйлийн 2-д “Ардчилсан ёс, эрх чөлөө, тэгш байдал, үндэсний эв нэгдлийг хангах, хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн.” гэж заасан байдаг. Энэ хуулийн 5 дугаар бүлгийн 1-д “Монгол Улс дэлхийн эдийн засгийн хөгжлийн түгээмэл хандлага, өөрийн орны өвөрмөц онцлогт нийцсэн олон хэвшил бүхий эдийн засагтай байна.” гэж тусгагдсан.

2010 оны байдлаар манай орны дотоодын нийт бүтээгдэхүүний 73.4 хувь нь хувийн хэвшилд бий болсон байна. Эндээс харахад манай эдийн засгийн үндэс нь гарцаагүй хувийн сектор байна.

1990 оноос Монгол Улс төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгаас зах зээлийн эдийн засагт шилжих шилжилтийг “цочир эмчилгээний арга” гэгчээр хийсэн нь бид бүхэнд тодорхой билээ. Зарим эрдэмтэд анхнаасаа “*оi-èè ÿì-èèÿÿíéé*” загварыг хэтэрхий эрсдэлтэй, ялангуяа нийгмийн салбарт хэтэрхий их гарз хохирол учруулах, урьдчилан харж болохооргүй олон муу үр дагавартай буруу арга гэж үзэж байсан. Гэтэл Хятад, Вьетнам зэрэг орнууд шилжилтийг “градуалист” буюу “үе шатлалт” загвараар хийсэн тул өөрчлөлт, шинэчлэлт нь үйлдвэрлэлийн нэгэнт бий болсон потенциал, ажил эрхлэлтийн хүрсэн түвшинг эвдэлгүй, шилжилтийн хугацаанд ажилгүйдэл, ядуурлыг аль болон бага түвшинд байлгах боломж өгсөн байдаг.

Эндээс харахад Монгол дахь зах зээлийн эдийн засгийн төлөвшилт анхнаасаа нийгмийн баримжаатай бус, харин ч их эрсдэлтэй ажилгүйдэл,

ядуурлыг араасаа дагуулсан шилжилт байсныг 20 жилийн өндөрлөгөөс харахад тодорхой байна. Харин сүүлийн 2008 оны сонгуулиар хүн амдаа мөнгө амлаж гарч ирсэн улс төрийн намууд хүн амд бэлэн мөнгө тарааж байгааг эс тооцвол манай өнөөгийн эдийн засаг,нийгмийн хөгжлийн загварыг нийгмийн баримжаатай гэж үзэхэд хэцүү байгаа юм. Үүний учир шалтгаан нь нийгмийн баримжаатай зах зээлийн эдийн засгийн үндсэн зарчмуудын талаар ард авч үзэхэд тодорхой болно.

Монгол Улсын Их Хурлаас 1996 оны 5 сарын 3-нд батлан гаргасан “ Монгол Улсын хөгжлийн үзэл баримтлал” нь манай орны хөгжлийн загвар, ирээдүйн чиг хандлагыг тодорхойлсон зах зээлийн эдийн засагт шилжсэний дараа хөгжлийн үзэл баримтлалаа албан ёсоор тодорхойлсон анхны баримт бичиг болдог. Энэхүү үзэл баримтлалд “ Монгол Улс ойрын ирээдүйд оюуны болон технологийн шинэ суурьт тулгуурласан, экспортын баримжаатай, харьцангуй биеэ даасан эдийн засагтай үйлдвэржсэн орон болно” гэж тодорхойлсон байдаг.

2008 оны 1 –р сэд УИХ-ын №12 тогтоолоор батлагдсан “ Монгол Улсын Мянганы хөгжлийн зорилгод суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлого” –д энэхүү цогц бодлогын зорилт нь хувийн хэвшил тэргүүлсэн эдийн засгийн эрчимтэй өсөлт, монгол хүний хөгжил, түүний дотор боловсрол, эрүүл мэнд, түүнчлэн шинжлэх ухаан, технологи, байгаль орчны тогтвортой хөгжлийг тэргүүлэх чиглэл болгож, хүнийг оюунжуулж, чадваржуулах замаар Мянганы хөгжлийн зорилтын биелэлтийг хангах, өндөр технологи, байгаль орчинд халгүй үйлдвэрлэл, үйлчилгээг эрхэмлэн өсөлтөө хангадаг мэдлэгт суурилсан эдийн засагтай болох, иргэддээ үйлчилдэг, хүний эрх, эрх чөлөөг хангадаг, авлига, хүнд суртлаас ангид ардчилсан төрийн тогтолцоог төлөвшүүлэх замаар Монгол Улсын бүрэн эрхт байдлыг хамгаалан бэхжүүлж, дундаж хөгжилтэй улс болгоход оршино гэж тодорхойлжээ.

Энэхүү цогц бодлогод Монгол Улсын Үндэсний хөгжилд баримтлах зарчмыг дараахь байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- ардчилсан ёс, шударга ёс, хүний эрх, эрх чөлөө, тэгш байдал, үндэсний эв нэгдлийг хангах;
- улс орны хөгжилд иргэн бүр оролцох, хувь нэмрээ оруулах, манлайлах нөхцөлийг бүрдүүлэх;
- хөгжлийн бодлого, стратегийг хэрэгжүүлэх чадамж, бүтцийг бий болгох;
- зах зээлийн эдийн засагт суурилсан хөгжил эрчимтэй, тогтвортой байх;
- хөрөнгө нөөцийг бодлогын тэргүүлэх чиглэл, эрэлт хэрэгцээнд суурилан хуваарилах, түүнийг ил тод байлгах, зарцуулалтыг хянан гүйцэтгэлийн үр дүнг үнэлж дахин төлөвлөх;
- бүх талын түншлэлд суурилах;
- өөрчлөгдөмтгий нөхцөл байдалд уян хатан зохицох чадамжтай болох;

- бүх шатанд хариуцлага хүлээх чадвартай болох, ил тод байх, хууль дээдлэх гэж тусгасан.

“ Монгол Улсын Мянганы хөгжлийн зорилгод суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлого”д Монгол Улсын хөгжлийг 2021 он хүртэл 2 үе шаттайгаар авч үзсэний дотор 2009-2015 онд уул уурхайн салбарын эрчимтэй өсөлтөд голлон тулгуурлан эдийн засгийн эрчимтэй хөгжлийг хангаж, үндэсний хөрөнгийн хуримтлалыг бий болгох, 2015- 2021 онд мэдлэгт суурилсан эдийн засгийг бий болгохоор төсөөлсөн байдаг.

Үндсэн хуулийн заалт, 1996 онд тодорхойлсон Монгол Улсын хөгжлийн үзэл баримтлал, Үндэсний хөгжлийн цогц бодлогоос харахад Монгол Улс бол иргэнээ дээдэлсэн, ардчилсан шудрага ёсыг эрхэмлэсэн, зах зээлийн эдийн засагтай улс юм. Эндээс хөгжлийн загвар маань мөн л хүнийг төвдөө тавьсан загвар байна. “ Монгол Улсын хөгжлийн үзэл баримтлал”- баримт бичгээс өөр хөгжлийн загвараа тодорхойлсон баримт бичиг алга байна. Гэхдээ энэхүү баримт бичигт эдийн засгийн бүтцийн асуудалд голлон анхаарсанаас зах зээлийн эдийн засгийн үндсэн зарчмуудыг хэрхэн хэрэгжүүлэх, нийгмийн хөгжлийн асуудлуудыг хэрхэн шийдвэрлэх, эдийн засаг дахь төрийн оролцоо зэрэг өргөн хүрээтэй асуудлуудыг тусгаагүй байна. Монгол Улсын хөгжлийн загварыг үндэслэлтэй, нарийн цэгцтэй тодорхойлох шаардлага байна.

Гэвч цаасан дээр бичсэн зорилт нэг хэрэг амьдрал дээр бодит байдал ямар байгааг судлан тогтоох, тохиодож байгаа бэрхшээл, хүндрэл , сорилтууд, тэдгээрийг шийдвэрлэх, засаж залруулах арга замын талаар санал, дүгнэлт гаргах чухал байна.

Нийгмийн баримжаатай зах зээлийн эдийн засаг (НБЗЗЭЗ) гэж юу вэ?

Дэлхийн II дайны дараа ХБНГУ –д “Нийгмийн баримжаатай зах зээлийн эдийн засаг” –г хөгжлийнхөө загвар болгон шинээр сонгож хэрэглэж эхэлсэн бөгөөд энэ нь Валтер Үйкен, Франц Бёом, Вилхелм Рёнке нарын “Фрайбургийн сургууль” буюу Ордолиберализм гэгддэг өмнөх үеийнхэний олон ажлуудыг сайжруулан шинэчилсэн Alfred Muller Armack, Людвик Эрхард нарын ажлууд дээр үндэслэгдсэн байжээ. Энд Ордолиберализм гэдэг үзэл баримтлал нь хуулийн хүрээ нь эдийн засгийн чөлөөт өрсөлдөөн болон зах зээл дээрх иргэдийн эрх чөлөөг баталгаажуулдаг зах зээлийн эдийн засгийн байгууллалын хэлбэр гэж үздэг.

НБЗЗЭЗ гэдэг үзэл баримтлал Баруун Германд 1948 оноос эхэлсэн эдийн засгийн хөгжлийн бодлогоос хэрэгжиж эхэлсэн ажээ. Энэхүү үзэл баримтлалыг үндэслэгч нь Германы эрдэмтэн Alfred Muller Armack бөгөөд түүний 1946 онд хэвлүүлсэн “Эдийн засгийн хяналт ба зах зээлийн эдийн засаг” (“Control and Market Economy”) номонд нь нийгмийн баримжаатай зах зээлийн эдийн засгийн үндсэн гол үзэл баримтлал нь тусгагджээ.

Alfred Muller Armack анх удаа **нийгмийн хариуцлагатай зах зээлийн эдийн засгийн тухай** үзэл санааг гаргаж иржээ. Урт хугацаанд нийгмийн хөгжлийг сайн тал уруу нь өөрчилж чадах, эдийн засгийн хөгжлийн тийм загварыг бий

болгохыг санал болгосон нь НБЗЗЭЗ –ын гол агуулга болж байна. Muller Armask-ийнхээр НБЗЗЭЗ –ын үзэл баримтлал нь нээлттэй, уян хатан бөгөөд нийгмийн хөгжлийн шаардлагаар түүнд шаардлагатай өөрчлөлтийг оруулж болох ажээ.

Alfred Muller Armask-ийнхээр НБЗЗЭЗ нь **чөлөөт зах зээлийн эдийн засгийг нийгмийн тэнцвэртэй (баланслалттай) хөгжилтэй хослуулахыг хэлнэ.**

НБЗЗЭЗ –ын онолын болон түүхэн эх үүсвэр нийгмийн баримжаатай дараах 2 төрлийн онол болох либерализм (Эрх чөлөө гэсэн гол утгаараа) болон нийгмийн хууль зүй (Social justace) гэсэн нийгмийн философоос эх үүсвэртэй ажээ. НБЗЗЭЗ –ыг энэ утгаар нь авч үзвэл эрх чөлөө болон хууль ёс хоёрын харилцан хамаарал, харилцан зөрчлийг зүй зохистой шийдвэрлэж, нийгмийн үнэт зүйлийг бий болгоход чиглэсэн хөгжлийн бодлого, загвар юм.

Германд хэрэгжүүлсэн НБЗЗЭЗ –ын практик үр дүнг урт хугацаанд авч үзэхэд дараах 4 үе шаттай байсан гэж үздэг. Үүнд:

I үе шат-1948-1966 он. Энэ үе шатанд НБЗЗЭЗ –ын үндсэн зарчмууд болон элементүүдийг нэвтрүүлэх үе байсан гэж үздэг. Энэ үеийн онцлог нь Баруун Германы 1950-иад оны эдийн засгийн үсрэнгүй хөгжлийн үе байсан бөгөөд үйлдвэрлэлийн процесст технологийн үндсэн шинэчлэлт хийж, хүн амынх нь амьжиргааны стандарт эрс өссөнөөр илэрч байв. Үүнд АНУ-ын зүгээс Маршаллын төлөвлөгөөг хэрэгжүүлж, дэмжсэн явдал их нөлөөлсөн аж

II үе шат - 1967-1978 онд үргэлжилсэн бөгөөд энэ үе шатанд нийгмийн баримжаатай бодлогыг Кейнсын номлол болон интервенцын номлолоор эрэлтийн менежментын бодлоготой хослуулан хэрэгжүүлжээ.

III үе шат - 1979-1989 онд үргэлжилсэн бөгөөд эрэлтийн менежментийн бодлого үр дүнгүй болсныг цохон тэмдэглэж, төрийн эдийн засгийн бодлого нь зах зээлийн үйл явцыг улам хөхүүлэн дэмжсэн бодлогыг явуулж, харин институтчлэлийн бодлого зогсонги байдалд орсон үе байв.

IV үе шат – 1990 оноос эхэлжээ. Энэ үеийн онцлог нь институтчлэлийн шинэчлэлтийг өөрчлөгдсөн “баян улс орон” , өөрчлөгдсөн “нийгмийн бодлого”-той уялдуулан хэрэгжүүлжээ. Энэ шатанд эдийн засгийн болон нийгмийн хөгжлийн баланслалтыг тогтооход энэ бодлого чиглэгдсэн ажээ.

Зах зээлийн эдийн засгийн нийтлэг шинж, гол зарчмууд

Нийгмийн амьдралын үндэс нь хүмүүсийн зорилго, чиглэлтэй үйл ажиллагаа гэж үздэг. Энэ үйл ажиллагаа нь зах зээлийн эдийн засгийн хэлбэрээр хэрэгждэг. Эндээс нийгмийн амьдралын үндэс нь зах зээлийн эдийн засаг юм. Эдийн засгийн үйл ажиллагааны цөм нь хүмүүс, тэдгээрийн хувийн хүсэл, эрэлт хэрэгцээ бөгөөд эдгээр нь хүн бүрийн хувьд мэдээж өөр өөр байна. Эдийн засаг нь хүмүүсийн материаллаг хэрэгцээг хангахын тулд өгөгдсөн хязгаарлагдмал нөөцийг хуваарилж , ашигладаг.

Хүмүүсийн эдийн засгийн үйл ажиллагаа нь өөрсдын болон бусдын хэрэгцээг хангахад чиглэгдсэн байдаг. Бүх хэрэгцээг тэнцүү хангахын тулд байгаа эдийн засгийн нөөц хүрэлцээгүй тул түүнийг байршуулах, хуваарилахад зайлшгүй өрсөлдөөн гарч ирдэг.

Зах зээлийн эдийн засгийн үйл ажиллагаа чөлөөт, өрсөлдөөнт нөхцөлд монопольгүй орчинд явагдаж, үнэ эрэлт, нийлүүлэлтийн нөлөөгөөр тодорхойлогдох ёстой.

Зах зээлд нэг талаас үйлдвэрлэгч, нөгөө талаас хэрэглэгч оролцоно. Үйлдвэрлэлийн үндсэн зорилго нь бараа, үйлчилгээний борлуулалтын орлогоос их ашиг олох явдал. Харин хэрэглэгчийн үндсэн зорилго нь боломжийн бага зардлаар хэрэгцээт зүйлээ зах зээлээс олж авах явдал байдаг. Эдгээр ашиг сонирхлыг зах зээлийн эдийн засаг тэнцвэржүүлэх үүрэгтэй.

Асуулт: 1. Өнөөдөр Монгол Улсад үнэ эрэлт, нийлүүлэлтийн нөлөөгөөр тодорхойлогдож байгаа юу?

Хэдийгээр 1990 оноос үнийг чөлөөлөх талаар арга хэмжээ авсаар ирсэн боловч одоог хүртэл бүх бараа, бүтээгдэхүүний үнэ бүрэн чөлөөлөгдөөгүй байна. Хүн амын амьжиргааны түвшин доогуур байгаа өнөөгийн нөхцөлд төрөөс ахуйн хэрэглээний цахилгаан, дулааны үнэ болон шатахууны үнийг зориуд хянаж, зохицуулсаар байгаа. Үүний улмаас нүүрсний уурхай, цахилгаан станцууд зэрэг зарим салбар зах зээлийн харилцаанд бүрэн шилжээгүй байна. Гэхдээ энд бүгд хувийн салбарт шилжсэн байх албагүй.

Үнэ нь чөлөөлөгдсөн бараа, бүтээгдэхүүний хувьд гэхэд үнэ эрэлт, нийлүүлэлтийн нөлөөгөөр тодорхойлогдох зах зээлийн дээрх зарчим бүрэн үйлчилдэггүй, бараа бүтээгдэхүүний үнэ өснө үү гэхээс өрсөлдөөний дүнд буурах нь нэн ховор байна.

Асуулт: 2. Зах зээлийн эдийн засгийн үйл ажиллагаа чөлөөт, өрсөлдөөнт нөхцөлд монопольгүй орчинд явагдах зарчим хэрэгжиж байна уу? Бүрэн хэрэгжиж байна гэж хэлэхэд хэцүү. Хэдийгээр Монгол Улсад өрсөлдөөний тухай хууль байдаг боловч хэрэгждэггүй. Бараа, бүтээгдэхүүний үнээ хууль бусаар өсгөдөг, үгсэн тохирч үнээ нэмдэг үзэгдэл гарсаар ирсэн. Шударга өрсөлдөөнийг хянан зохицуулах тусгай агентлаг ажилладаг боловч зах зээлд монополь, олигополь компаниуд ноёрхсоор байна.

Зах зээлийн эдийн засгийн нэг чухал зарчим нь төрөөс хувийн өмчийг хууль ёсоор баталгаатай хамгаалсан байх явдал юм. Үндсэн хуулийн 5 дугаар зүйлийн 2-т “Төр нь нийтийн болон хувийн өмчийн аливаа хэлбэрийг хүлээн зөвшөөрч, өмчлөлийн эрхийг хуулиар хамгаална.” гэж заасан байдаг. Хувийн өмчийн талаар манай оронд тусгайлсан хууль байгаа эсэх, зах зээлийн эдийн засгийн энэхүү зарчим хэрхэн хэрэгжиж байгаа талаарх асуудлыг өнөөдөр өөр судлаач тусгайлан хөндөнө.

Зах зээлийн эдийн засгийн бас нэг гол онцлог нь хувь хүний эрх чөлөөг дээд зэргээр баталгаажуулдаг. Зөвхөн зах зээлийн эдийн засгийн тогтолцооны нөхцөлд хувь хүн эрх чөлөөгөө эдлэх боломжтой гэж үздэг. Монгол Улсад хувьд хүний эрхийг хамгаалах, эрх чөлөөг нь баталгаажуулах талаар социализмаас уламжилсан туйлын хайхрамжгүй ханддаг тогтолцоотой гэж дүгнэхэд буруудахгүй. Манай оронд хүний эрх чөлөөг хэр зэрэг хангаж байна вэ? гэдэг асуултад хариулахад түвэгтэй, олон тохиодолд хангалтгүй гэсэн дүгнэлт гарах өндөр магадлалтай. Гадаад байсан иргэнээ гэмт хэрэгт сэжиглэн

улс дамжуулан хүчээр баривчлан авчирч, эрүүдэн шүүж, улмаар амь насыг нь хороосон баримт нь улс хоорондын харилцаанд асуудал үүсгэсэн билээ. 2008 оны 7 дугаар сарын 1 –ний үйл явдлын талаар УИХ дээр явагдсан хэлэлцүүлэгт хүний эрх ноцтой зөрчигдсөнийг их хурлын олон гишүүд хүлээн зөвшөөрч байсан. Манай орны Үндсэн хуульд тунхаглагдсан хүний үндсэн эрхүүд ноцтой зөрчигдсөөр ирсэн баримтууд хэвлэл, мэдээллийн хэрэгслээр цацагдсаар ирсэн.

Зах зээлийн эдийн засгийн нөхцөлд хувь хүн өөрийнхөө эрх чөлөөг эдлэхдээ нийгмийн бусад гишүүдийн эрх ашгийг хохироохгүй байх үндсэн зарчимтай. Зах зээлийн эдийн засгийн харилцааны нөхцөлд төр хууль эрх зүйн тогтвортой орчинг бүрдүүлэх үүрэгтэй байдаг. Гэтэл манай хуулиуд байнга өөрчлөгддөг. Ашигт малтмалын хууль гэхэд 1996 оноос хойш хэд хэд өөрчлөгдсөн байх жишээтэй. Энэ нь гадаадын хөрөнгө оруулагчдын итгэлийг хесөрдүүлэх, тэдний хувьд хууль эрх зүйн тогтворгүй орчинтой, нэлээд эрсдэлтэй орон болж байгаа юм. Үүнийг төр хуулиар зохицуулдаг. Гагцхүү хууль хүн бүрт тэгш үйлчилдэг, шүүх тогтолцоо шудрага, хүн бүр хуулиа дээдэлдэг байх ёстой. Монголын нөхцөлд энэ хамгийн их асуудалтай байгаа сэдэв болсоор ирсэн. Монгол Улсад хангалттай олон хууль батлагдсан боловч түүний хэрэгжилт туйлын хангалтгүй байгааг энэ чиглэлээр болсон олон удаагийн эрдэм шинжилгээний хурал дээр дүгнэсэн. Ард иргэд ч мөн ийм бодолтой явдаг. Учир нь олон тохиолдолд батлан гаргасан хууль нь гадны улс орнуудаас хуулбарласан, иргэд, иргэний нийгмийн оролцоогүй боловсруулсан, амьдралаас тасархай, эсвэл хэсэг бүлэг хүмүүсийн эрх ашигт нийцсэн, тусгайлсан цоорхойтой хуулиуд байдаг. УИХ-аас 2010 онд батлан гаргасан “урт нэртэй” гэгч хууль огт хэрэгжихгүй байгааг дээр дооргүй ярьж бичсээр ирлээ.

Манай хуулиуд зарим тохиолдолд хоорондоо зөрчилдсөн заалтуудтай, асуудлыг аль хуулийнхаар нь шийдвэрлэх нь тодорхой бус байдаг. Жишээ нь ашигт малтмалын нөөц ашиглалтын төлбөрийг улс, орон нутгийн төсөвт төлнө гээд “Ашигт малтмалын тухай” хуулинд байдаг бол” Монгол Улсын нэгдсэн төсвийн тухай “ хуулинд сумын төсөвт 10% оруулахаар тусгасан хэрнээ хэрэв ашигт малтмалын нөөц ашиглалтын төлбөрийн орлого нь сумын төсвөөс давсан тохиолдолд олгогдохгүй байхаар заасан байдаг. Яг ийм шалтгаанаар Цогтцэций сум Таван Толгойн ордын ашигт малтмалын нөөц ашиглалтын төлбөрөөс юу ч хүртэж чаддаггүй.

Нөгөө талаасаа Монгол Улсад хамгийн анхаарал татаж байгаа асуудал нь иргэн бүрд хууль тэгш үйлчилдэггүй. Мөнгөтэй, эрх мэдэлтэй хүмүүст хууль үйлчилдэггүй байдал хаа сайгүй түгээмэл бөгөөд энэ нь ямар нэг баталгаа нотолгоо шаардахгүй илэрхий зүйл болсон. Энэ нь Монголын нийгмийн шудрага бус байдлын гол илрэл болж байна.

Үндсэн хуулийн 14 дүгээр зүйлийн 1-д “Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна” гэж заасан заалт амьдралд тэр бүр хэрэгждэггүй.

Нийгмийн баримжаатай зах зээлийн эдийн засгийн үндсэн зарчмууд

Зарчим 1. Нийгмийн баримжаатай зах зээлийн эдийн засаг бол юуны түрүүнд зах зээлийн эдийн засаг юм.

Бидний дээр дурьдсан зах зээлийн эдийн засгийн үндсэн зарчмуудыг нийгмийн баримжаатай зах зээлийн эдийн засагт мөрдлөгө болгон хэрэгжүүлдэг. Эдгээрээс хэд хэдэн зүйлийг онцлон авч үздэг.

Зах зээлийн эдийн засгийн гол зарчим нь нийгмийн хамгийн үнэт зүйл нь хувь хүний эрх чөлөө гэж үздэг. Энэ нь бүр Европын сэргэн мандалтын үеийн гүн ухааны үзэл баримтлал юм. Харин НБЗЗЭЗ –ийн удирдлагын гол механизм нь зах зээлийн механизм байх ёстой гэж үздэг. Нийгэмд өрсөлдөөний дэг журмыг жинхэнэ ёсоор хэрэгжүүлдэг, эдийн засагт монополь ноёрхол тогтохоос сэргийлж чаддаг, лоббистууд, ашиг сонирхлын бүлэглэлүүдээс өөрийгөө хамгаалж чаддаг хүчирхэг төр байх ёстой гэж үздэг. Харин Монгол Улсад улс төр, эдийн засгийн ашиг сонирхлоороо нэгдсэн бүлэглэлүүдийн эрх ашиг нийгмийн эрх ашгаас дээгүүр тавигддаг. Монгол Улсад өнөөдөр парламентийн гол 2 улс төрийн нам төрийнхөө дээр нь гарсан байдалтай байгаа. Монголын эдийн засаг, улс төр, нийгмийн чухал тулгамдсан асуудлыг юуны өмнө намуудын бүлэг дээрээ хэлэлцэн тохироод парламентаас тэр дагуу л шийдвэр гардаг. Эдийн засаг, нийгмийн хөгжлийн асуудлаар төрөөс гаргасан шийдвэрт иргэдийн оролцоо, иргэний нийгмийн оролцоо туйлын хангалтгүй, байвал ёс төдий, билэг тэмдгийн шинжтэй байгаа билээ. Энэ талаар иргэний нийгмийн төлөөлөгчид илүү тодорхой үгээ хэлж чадна.

Зарчим 2. Нийгмийн баримжаатай зах зээлийн эдийн засаг бол эдийн засгийн үр дүнг нийгмийн тэнцвэртэй байдалтай холбож өгдөг.

Хувь хүний эрх чөлөө, нийгмийн эрх тэгш байдал хоёрын хоорондын уялдаа хобоо нь зөвхөн зах зээлийн эдийн засгийн тогтолцоонд хэрэгжих боломжтой байдаг ажээ.

Alfred Muller Armask нийгмийн баримжаатай зах зээлийн эдийн засгийг “зах зээл дээрх эрх чөлөөний зарчмыг нийгмийн эрх тэгш байдалтай холбох” гэж тодорхойлжээ.

Зах зээлийн эдийн засгийн нөхцөлд нийгмийн тэгш байдлыг хангахдаа “үнэгүй хоол гэж байдаггүй” гэсэн зарчмыг баримталдаг. Гол санаа нь манайх шиг улс төрийн намууд нь төрийнхөө дээр гарсан тул сонгуульд амласан амлалтаа биелүүлж, дахин сонгогдох зорилгоор иргэн бүрдээ бэлэн мөнгийг хавтгайруулах тараадаг ийм үзэгдэл байдаггүй.

Харин зах зээлийн өрсөлдөөнд оролцох боломжгүй учир зах зээлийн ашиг орлогоос хүртэх боломжгүй хүүхэд, хөгшид, хөгжлийн бэрхшээлтэй, өвчтэй иргэдэд амьдралын баталгааг нь төр хангаж, эдийн засгийн хөгжлийн үр шимээс хүртэх боломжийг олгодог байна.

Манай оронд төрөөс нийгмийн халамжийн бодлогыг хэрэгжүүлэхдээ жинхэнэ хүртэх ёстой зорилтот бүлэгтээ төвлөрүүлэх тал дээрээ хангалтгүй, ихэвчлэн нийт хүн амд хавтгайруулсан байдлаар хэрэгжүүлдэгээс эдийн засгийн үр дүнг үр ашиг муутай хуваарилсаар ирсэн.

Нийгмийн баримжаатай зах зээлийн эдийн засагтай ХБНГУ –д нийгмийн тэгш байдлыг хангахын тулд төрөөс орлого, өмч хөрөнгийн хуваарилалтын идэвхтэй бодлого явуулж, нийгмийн тэгш бус байдлыг багасгах (жишээлбэл, ажиллагсдыг өмчтэй болгох г.м), түүнчлэн эрх чөлөөний зарчмыг даган мөрдөж, зарлага, орлого, өмч хөрөнгийн (татварын г.м) дарамтын ялгааг арилгах бодлогыг зориуд хэрэгжүүлдэг байна. Гэхдээ энд эдийн засгийн үр дүн, эдийн засгийн хүчин чадал гэдэг ойлголтыг орхигдуулж болохгүй. Эдийн засгийн хүчин чадал нийгмийн зорилтуудыг хэрэгжүүлэх үндсэн нөхцөл болдог. Энэ утгаараа хувь хүний эрх чөлөө, нийгмийн шударга байдал, эдийн засгийн хүчин чадал нь нийгмийн баримжаатай зах зээлийн эдийн засгийн бие биетэйгээ нягт холбоотой чухал бүрэлдэхүүн хэсгүүд болдог байна. Монгол Улсад орлогын тэгш бус байдлыг багасгах тусгай татвар байдаггүйгээс ядуурал буурдаггүй.

Монгол Улсын эдийн засаг өндөр өсөлттэй байгаа боловч ядуурал огт буурдаггүй, эдийн засаг тэлээд байгаа хирнээ ажлын байр тэр хэмжээгээр нэмэгддэггүй, өөрөөр хэлбэл, эдийн засгийн хөгжлийн үр дүн нийгмийн хөгжил, хүн амын амьжиргаанд бууж ирдэггүй, наалддаггүй хачирхалтай тогтолцоо бий болсон байна. Зөвхөн сүүлийн 10 жилд Монгол Улсын ДНБ-ний хэмжээ зэрэгцүүлэх үнээрээ 2 дахин өссөн бол нийт хүн амд ядуучуудын эзлэх хувь огт буураагүй, харин ч бага зэрэг нэмэгдсэн байгаа. 1998 оны судалгаагаар ядуурлын түвшин 36 хувь байсан бол 2010 онд хүн амын 39,2 хувь нь ядуу, үүний дотор хөдөөд бүр 47,8 хувьд хүрсэн байна. Гэтэл Монгол Улс НҮБ-ээс зарласан Мянганы хөгжлийн зорилтуудад 2000 онд нэгдэн орж, хүн амын ядуурлаа 2015 он гэхэд 2 дахин бууруулах үүрэг хүлээсэн байгаа. Өнгөрсөн 11 жилийн байдлаар энэ чиглэлээр ямар ч ахиц өөрчлөлт гарсангүй бөгөөд одоо үлдсэн 4 жилд байдал өөрчлөгдөхгүй нь тодорхой байна. Өнгөрсөн 21 жилд үе үеийн Засгийн газрууд, сонгуулд оролцсон улс төрийн хүчнүүд хүн амын ядуурлыг бууруулах талаар том том амлалт өгч, өндөр зорилтууд дэвшүүлж, ажиллаж ирсэн боловч үр дүн нь нэг иймэрхүү л байлаа. Тухайлбал, одоогийн төрийн эрхэнд байгаа МАН 2004 оны сонгуульд “Төрөө хямралаас аварч, түмнээ ядуурлаас гаргана” гэсэн уриатай оролцож, ялаад Засгийн газраа байгуулж байсан. Өнөөгийн ардчилсан Ерөнхийлөгч хэвлэлээр ядууралтай дайн зарлаж гарч ирсэн.

Монголын нийгмийн дотор баян, ядуугийн зааг ялгаа улам нэмэгдсээр байгаа нь бидний нүдэн дээр илхэн байна. Үндэсний Статистикийн Хорооноос жил бүр явуулж ирсэн нийгэм, эдийн засгийн судалгааны дүнгээс үзэхэд хүн амын орлогын тэгш бус байдлыг харуулдаг Жини коэффициент 2003 онд 0.33 байсан бол 2011 оны 2 р улиралд 0,368 болж, нэмэгдсэн байгаа нь өнгөрсөн хугацаанд хүн амын орлогын тэгш бус байдал гүнгийрсэнийг харуулав. Төрийн байгууллагууд, албан тушаалтанууд авилгад гүнзгий автагдсан, олон улсын байгууллагуудаас гаргасан судалгаагааны дүнгээр Монгол Улсын авилгалын индекс өндөр гарсан байдаг. Бусад улс оронд саятан, тэрбумтанууд бизнесийн

хүрээнэс төрдөг бол тэд Монголын төрийн албанаас төрөн гардаг болсон хачирхалтай байдал бий болсон.

Өнөөгийн Монголын нийгмийн нэн тулгамдсан шийдвэрлэх асуудал нь ажилгүйдэл юм. Хүн ам, орон сууцны 2000 оны тооллогоор ажилгүйдлийн тоо 164,9 мянга болж, ажигүйдлийн түвшин ажиллах хүчний 17.5 хувийг эзэлж байсан бол 2010 оны тооллогоор ажилгүйдчүүд 164,1 мянга, ажигүйдлийн түвшин 15,3 хувь гарчээ. Сүүлчийн тооллогын дүнгээр ажилгүйдэл 20-24 насны залуучуудын дунд 23,8 хувь байгаа нь бүр ноцтой юм.

Энэ онд Арабын ертөнц даяар өрнөсөн нийгмийн бухимдал, тэмцэл хөдөлгөөний гол шалтгаан нь нийгмийн шудрага бус байдал, бурангуй засаглал, ажилгүйдэл, ядуурал байсан. Египтэд гэхэд ажилгүйдлийн түвшин 10 гаруй хувь байсан байдаг. Гэтэл манай оронд энэ үзүүлэлт түүнээс ч дээгүүр байна.

Энэ бүхнээс харахад өнгөрсөн 10 жилд нийгмийн салбарт олигтой ахиц дэвшил огт гараагүй гэж дүгнэж болохоор байна. Энэ байдал нь Монгол Улсад нийгмийн баримжаатай зах зээлийн эдийн засгийг төлөвшүүлэх хэрэгцээ, шаардлага байгааг илтгэн харуулж байна.

Зарчим 3. Эдийн засгийн үр дүн, нийгмийн тэгш байдлын хоорондын харилцааг бие биеэ нөхөх буюу субсидиаритэтын зарчмаар шийдвэрлэдэг.

Энэ зарчмыг манай орны нөхцөлд ялангуяа онцгой анхаарч хэрэгжүүлэх шаардлагатай санагдлаа.

Аливаа шийдвэр гаргахдаа бие хүн болон бүлгүүдийн өөрсдийнх нь идэвх санаачилгыг төрөөс илүүд үздэг субсидиаритэтын зарчмыг нийгмийн баримжатай зах зээлийн эдийн засагт баримталдаг байна. Энэ зарчим манай оронд тэр бүр хэрэгждэггүй, манай бүх хууль эрх зүйд энэ зарчим хэр тусгалаа олсон эсэхийг судлах шаардлагатай. Хуулийнхан энэ тал дээр дүгнэлтээ хийх шаардлага гарна. Амьдрал өөрөө зах зээлийн нөхцөлд яг энэ чиглэлээр асуудлыг шийдвэрлэх сорилт, бодит байдлыг үүсгэж байна.

Ганц жишээ татая. Монголчууд өөрсдөө хийж чадах зүйл тухайлбал, нүүрсний томоохон ордуудыг эзэмшиж, олборлолт явуулах тал дээр хувийн хэвшлийнхэн санаачилга гаргаж (тухайлбал, Монгол 999 компани Таван Толгойн ордыг эзэмшихэд оролцохоо илэрхийлсэн), Энэржи Ресурс компани ордын тодорхой хэсгийг эзэмшдэг тул бүтээн босголтын ажлаа маш амжилттай хэрэгжүүлж байна. Энэ ордыг заавал гадаадын компанид эзэмшүүлэх шаардлага ч үнэндээ байгаагүй юм. Монголд мэргэжилтэй ажиллах хүч, хөрөнгө, технологи бүгд байгаа нь энэхүү Энэржи Ресурс компаны үйл ажиллагаанаас тодорхой харагдаж байна. Гэтэл төр энд заавал орж хутгалдаад , дээр нь төрийн зүгээс шийдвэрлэвэл зохих асуудлаа шийдвэрлэхгүй байна. Тухайлбал, Таван Толгой орд байгаа Цогтцэций сумын хот байгуулалт, дэд бүтцийн хөгжлийн төлөвлөлтийг сумын удирдлага нь хувийн компаниар хийлгээд явж байтал дээрээс зогсоож, төрийн байгууллага хот төлөвлөлтөө хийх ёстой гэсэн шийдвэрийг 2010 онд гаргаад харин нөгөө төрийн байгууллагууд нь одоо хүртэл тэр ажлаа хийгээгүй, энэ суманд газар олголт, дэд бүтцийн хөгжлийн

асуудал зогсонги байдалд орчихсон байдалтай байна. 2011 оны 9 сард бид тус сумын Засаг дарга Цог-Өрнөхтэй газар дээр нь уулзсан тэмдэглэлээсээ энэ жишээг кейс болгон авлаа.

Субсидиаритэт буюу бие биеэ нөхөх зарчмын үндсэн санаа нь нийгмийн жижгэвтэр, бусдаас хамаарал бүхий нэгжүүд бие даан амжилттай хэрэгжүүлж чадах аливаа зүйлийг тэдний оронд хийж гүйцэтгэх, тэдгээрийн хийж бүтээснийг дээдэх бүлгүүд нь өөрсдөө ашигладаг бол шудрага явдал зөрчигдөж байна гэж үздэг.

Субсидиаритэт зарчмын дагуу эдийн засгийн тодорхой салбарыг зах зээл, зохион байгуулалт буюу төр гэсэн зохицуулалтын механизмд хамруулахдаа төвлөрсөн бус удирдлагын механизмыг баримталдаг байна. Энэхүү зарчим нь дараахь үр дагаварыг бий болгодог байна.

1. Эхний хувилбар нь эдийн засгийн шийдэл гаргахыг зах зээлийн зохицуулалтын механизмд даатгах явдал юм. Ингэхдээ зах зээлд оролцогсдын зарим нь нийт эдийн засгийн талаас дүгнэхэд нийгэмд бүхэлд нь ээлтэй үр дүнд хүргэх ёстой гэж үздэг.
2. Хоёрдахь хувилбар нь зөвхөн хувийн ашиг сонирхлыг эрхэмлэх нь нийт эдийн засаг буюу нийгэмд тустай үр дүнд хүрэхгүй тохиолдолд хувийн ашиг сонирхол болон нийт эдийн засгийн буюу нийгмийн эрх ашигийн хоорондын зөрчлийг холбогдох арга хэмжээг авч шийдвэрлэх боломжтой тохиолдолд төрөөс хувийн салбар дахь үйл явдалд нөлөөлөх шаардлага гардаг байна. Ингэхдээ төрийн янз бүрийн түвшний байгууллагууд нийгмийн эрх ашгийг хохироон зөвхөн өөртөө ашигтай үр дүн буюу баталгаажуулалтыг зорилгоо болгосон ашиг сонирхлын зохион байгуулалттай бүлгүүдийг шахалтанд хаалт хийж чаддаг байх нь чухал гэж үздэг.
3. Гуравдахь тохиолдол нь хувийн секторын оролцоогүй, дан ганц төрийн удирдлагын шийдвэрлэх асуудлууд байдаг ажээ.

Эдийн засгийн тодорхой салбаруудыг дээр дурьдсан 3 арга замын аль нэгэнд шууд хамааруулах боломж байхгүй. Тодорхой нөхцөл байдлыг нь заавал харгалзан үзэж аль хувилбарыг хэрэглэхээ шийдвэрлэнэ. Гэсэн хэдий ч дээрх 3 тохиолдлын алиных нь ч хувьд хувийн өмчид тулгуурласан эдийн засгийн зохицуулалтын механизмыг ажилуулах угтвар нөхцөл, боломжоор хангах үүргийг төр нь хүлээдэг байна. Эдгээр угтвар нөхцөлийг хэрэгжүүлэх нь НБЗЗЭЗ-ийн үндэс суурь нь болдог байна.

Дүгнэлт

1. Манай орны хөгжлийн өнөөгийн загвар ямар шинж төрхтэй байгаа талаар судалгаа хомс байна.
2. Манай орон ирээдүйн хөгжлийн загвараа цэгцтэй нарийн тодорхойлоогүй байна.
3. Монгол Улсын Үндсэн хуульд тусгагдсан заалтууд бүрэн хэрэгжихгүй байна.
4. Зах зээлийн эдийн засгийн үндсэн зарчмууд Монгол Улсад бүрэн хэрэгжихгүй байна.
5. Монгол Улсад нийгмийн баримжаатай зах зээлийн эдийн засгийг жинхэнэ ёсоор төлөвшүүлэх хэрэгцээ, шаардлага байна. Илтгэлд дурьдсанаар сүүлийн 10 жилд Монгол Улсын нийгмийн хөгжилд олигтой ахиц дэвшил огт гараагүй байгаа нь үүнийг нотлож байна.

Санал, зөвлөмж

1. Монгол Улсын ирээдүйн хөгжлийн загварыг үндэслэлтэй, нарийн цэгцтэй тодорхойлох шаардлагатай.
2. Зах зээлийн эдийн засгийн үндсэн зарчмууд Монгол Улсад бүрэн хэрэгжихгүй байгаа тул энэ талаар олон улсын нэр хүндтэй байгууллагаар нэмэлт судалгаа хийлгэх, дүгнэлт гаргуулах шаардлага байна.
3. Ер нь Монгол Улс зах зээлийн эдийн засагтай орон мөн үү гэдэг дээр Европын Холбооноос хөндлөнгийн дүгнэлт гаргуулбал зохино.
4. Монгол Улсад нийгмийн баримжаатай зах зээлийн эдийн засгийг төлөвшүүлэх, Монгол Улс хэтийн хөгжлийн загвартаа энэ асуудлыг тодорхой тусгахыг санал болгож байна.
5. Монгол Улсад төлөвшиж байгаа зах зээлийн эдийн засгийг нийгмийн баримжаатай, илүү хүмүүнлэг болгох алс хэтийн зорилтыг дэвшүүлж, төр, иргэний нийгэм, бизнесийнхэн хамтран ажиллах шаардлагатай байна.
6. Эдийн засгийн үр дүн, нийгмийн тэгш байдлын хоорондын харилцааг бие биеэ нөхөх буюу субсидиаритэт зарчмаар шийдвэрлэдэг тогтолцоог манай оронд алс хэтдээ үе шаттайгаар хэрэгжүүлэх шаардлагатай байна.

Ном зүй.

1. Rolf H. Hasse, Hermann Schneider, Klaus Weigelt , Social Market Economy Principles and Implementation, 2008,

2. Christian L. Glossner and David Gregosz , 60 years of Social Market Economy: Formation, development and Perspectives of a peacemaking formula, 2010.
3. Доктор, профессор Ханс-Римберт –Хэммер, “Нийгмийн баймжаатай зах зээлийн эдийн засгийн үндсүүд”, монгол хэл дээрх орчуулга, 2011 он
4. Альфред Маршалл,” Эдийн засгийн ухааны зарчмууд”, Монсудар, 2011 он.
5. Монгол Улсын Үндсэн хууль, 1992 он, Улаанбаатар
6. Монгол Улсын Их Хурлын 1996 оны 26 дугаар тогтоолыг хавсралт: “ Монгол Улсын хөгжлийн үзэл баримтлал”
7. Монгол Улсын Их Хурлын 2008 оны 26 дугаар тогтоолын хавсралт: “Мянганы хөгжлийн зорилтод суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлого”
8. Үндэсний Статистикийн Хороо, Хүн ам, орон сууцны 2000 оны тооллогын дүн, 2001 он
9. Үндэсний Статистикийн Хороо, Хүн ам, орон сууцны 2010 оны тооллогын дүн, 2011 он
10. Үндэсний Статистикийн Хороо, Статистикийн эмхтгэл, 2010 он.
11. .Б.Батмөнх болон бусад “Шилжилтийн үеийн макро эдийн засгийн олон улсын нийтлэг асуудлууд” сэдэвт суурь судалгааны тайлан